



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭДИЙН
ОРОЛЦОО, ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС САНГИЙН ХӨРӨНГИЙН ХЭРЭГЖИЛТ,
ҮР НӨЛӨӨ БУУРЧ БАЙНА.

**АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ
ХӨРӨНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ**

АУДИТЫН КОД: АРА-2024/26-01-ШТА-ГА

Архангай аймаг 2024 он



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх
аудитор **Т.Байгалмаа**

Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер **Д.Нэргүйбаатар**

Утас: 77332860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор **Н.Алтантуяа**

Утас: 99338611 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn

Ахлах аудитор **Г.Цог-Эрдэнэ**

Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn

Ахлах аудитор **П.Цэцэгдулам**

Утас: 99339725 Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn

Аудитор **Н.Энхчимэг**

Утас: 89891150 Цахим хаяг: Enkhchimegn@audit.gov.mn

Аудитор **Л.Соёлмөнх**

Утас: 99051561 Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Аудитор **А.Пүрэвцэцэг**

Утас: 99746363 Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn

Аудитор **Б.Азантунгалаг**

Утас: 94658633 Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу.

| | | |
|--------------------------|--|------|
| Тайлан бэлтгэсэн: | ➤ Товчилсон үгийн тайлбар | 2-3 |
| Архангай аймаг дахь | ➤ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй | 3 |
| Төрийн аудитын газар | ➤ Үндсэн мэдээлэл | 4 |
| | ➤ Аудитын тайлан | 5-29 |

Тэргүүлэх аудитор
Т.Байгалмаа

Аудитын менежер
Д.Нэргүйбаатар

Ахлах аудитор
Н.Алтантуяа
Г.Цог-Эрдэнэ
П.Цэцэгдулам

Аудитор
Н.Энхчимэг,
Л.Соёлмөнх
А.Пүрэвцэцэг
Б.Азантунгалаг

2024 оны 07 дугаар сар
Уг тайланг
www.audit.mn сайтаас
үзнэ үү.

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах зүйл байвал
7033-2860 дугаарын
утас, 7033-3141
дугаарын факсаар
харилцана уу

Хаяг:
Эрдэнэбулган
сум Аймгийн
ЗДТГ-ын байр
3-р давхар 314 тоот

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА

1.1 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 831.0 САЯ ТӨГРӨГИЙН ОРЛОГЫГ БҮРДҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

1.2 АЙМАГ, СУМЫН ЗДТГ НЬ ИРГЭДИЙН САНАЛ АВААГҮЙ 67 ТАХ-Г ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

БҮЛЭГ 2. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАХ-НИЙ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ, АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

2.1. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БАРИМТЛААГҮЙ БАЙНА

2.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАХ-НИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЖ, ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА

3.1 ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАХ-НИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

3.2. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫГ УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД БҮРЭН МЭДЭЭЛЭЭГҮЙ, 1,035.7 САЯ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРТГЭЛ ТАЙЛАНД ТУСГААГҮЙ БАЙНА

| | |
|------------------------------------|-------|
| Дүгнэлт..... | 29 |
| Зөвлөмж | 30 |
| Холбогдох байгууллагын санал | 31 |
| Тайлан баталгаажуулсан тушаал..... | 32-35 |
| Хавсралт:Судалгаанууд | 36-41 |

Товчилсон үгийн тайлбар

| | |
|--------|--|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт |
| АМНАТ | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ИНХ | Иргэдийн нийтийн хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ОНХНС | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СТСХ | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| СХАА | Санхүүгийн хяналт, аудитын алба |
| ТЭЗҮ | Техник, эдийн засгийн үндэслэл |
| ТАХ | Төсөл, арга хэмжээ |
| ХОХБТХ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс |
| ГХБХБГ | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |

Хүснэгтийн жагсаалт

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|------------|---|-----------------|
| Хүснэгт 1 | ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг | 5 |
| Хүснэгт 2 | ОНХС-ийн төлөвлөлт | 7 |
| Хүснэгт 3 | ОНХС-ийн суурь тооцоолол | 8 |
| Хүснэгт 4 | ОНХНС-аас аймагт олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл | 9 |
| Хүснэгт 5 | Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт | 9 |
| Хүснэгт 6 | Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт | 10 |
| Хүснэгт 7 | Аймгийн ОНХС-ийн чиг үүрэг | 15 |
| Хүснэгт 8 | Сумдын ОНХС-ийн чиг үүрэг | 15 |
| Хүснэгт 9 | ОНХС-ийн 2023 оны хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилт | 17 |
| Хүснэгт 10 | Хөрөнгийн ашиглалтын байдал /аймаг, сумдаар/ | 19 |
| Хүснэгт 11 | Аймгийн удирдлагын мэдээллийн системийн хэрэгжилтийн байдлын судалгаа | 26 |

Дүрслэлийн товьёг

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|----|---|-----------------|
| 1 | 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга, хэмжээ | 6 |
| 2 | ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын санал авсан, эрэмбэлсэн байдал | 11 |
| 3 | Иргэдээс авсан санал асуулгын дүнгийн нэгтгэл | 12 |
| 4 | Худалдан авах ажиллагаа | 16 |
| 5 | Зорилтот түвшинд хүрсэн байдал | 18 |
| 6 | Ашиглагч байгууллагын чанарын үнэлгээ | 20 |
| 7 | Аймаг, сумын ИТХ-аас хяналт хэрэгжүүлсэн байдал | 22 |
| 8 | Санхүүгийн хяналт аудитын албанаас ИТХ-аас хяналт хэрэгжүүлсэн байдал | 23 |
| 9 | Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт /аймаг, сумдаар/ | 24 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал | 25 |



Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Ерөнхий Аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэв.

Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;*
- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;*
- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх асуудлыг тус тус хамруулав*

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, багийн засаг дарга, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардлагатай бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалт хийж, холбогдох албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.



Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- ✓ Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт;
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”;
- ✓ Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- ✓ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- ✓ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- ✓ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ, Н.Алтантуяа, П.Цэцэгдулам, аудитор Н.Энхчимэг, А.Пүрэвцэцэг, Б.Азантунгалаг, Л.Соёлмөнх нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024.05.14-2024.07.05-ны хооронд хийж гүйцэтгэлээ.



Үндсэн мэдээлэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-т “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааны журмыг Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар шинэчлэн баталжээ.

Аймгийн хэмжээнд 2023 онд ОНХС-ийн эхний үлдэгдэл 2,976.4 сая, тайлант онд 16,105.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 447 төсөл арга хэмжээг 12,341.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталж, гүйцэтгэлээр 352 ТАХ-г 12,226.4 сая төгрөгөөр санхүүжүүлсэн буюу 75.9 хувьтай байна. ОНХС-ийн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 3,091.8 сая төгрөг байна.

Хүснэгт 1. ОНХС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг (сая төгрөг)

| № | Сум | Эхний үлдэгдэл | ТАХ-ий тоо | Төсөвт өртөг | 2023 онд санхүүжсэн дүн | Гүйцэтгэл | Эцсийн үлдэгдэл |
|----|-------------------|-----------------|------------|-----------------|-------------------------|-----------------|-----------------|
| 1 | Ихтамир сум | 93.3 | 21 | 572.2 | 383.2 | 318.8 | 157.8 |
| 2 | Чулуут сум | 88.3 | 29 | 479.9 | 378.2 | 360.9 | 105.7 |
| 3 | Хангай сум | 57.7 | 15 | 468.8 | 405.7 | 374.1 | 89.4 |
| 4 | Тариат сум | 94.7 | 34 | 666.9 | 572.5 | 561.4 | 105.8 |
| 5 | Өндөр-Улаан | 39.7 | 34 | 691.5 | 569.2 | 577.0 | 32 |
| 6 | Цэцэрлэг сум | 73.1 | 40 | 822.8 | 521.8 | 626.6 | (31.80) |
| 7 | Хайрхан сум | 43.2 | 37 | 928.0 | 441.7 | 442.3 | 42.7 |
| 8 | Батцэнгэл сум | 107.9 | 20 | 378.8 | 370.3 | 286.5 | 191.6 |
| 9 | Өлзийт сум | 27.9 | 18 | 531.6 | 323.5 | 339.0 | 12.4 |
| 10 | Өгийнуур сум | 81.3 | 20 | 494.0 | 355.3 | 239.3 | 197.4 |
| 11 | Хотонт сум | 80.2 | 20 | 433.3 | 304.6 | 292.3 | 92.6 |
| 12 | Цэнхэр сум | 74.5 | 10 | 364.0 | 282.6 | 290.8 | 66.3 |
| 13 | Төвшрүүлэх сум | 16.0 | 15 | 393.7 | 328.7 | 354.5 | (9.80) |
| 14 | Булган сум | 65.8 | 20 | 658.5 | 314.3 | 313.3 | 66.9 |
| 15 | Эрдэнэбулган сум | 123.8 | 14 | 479.3 | 461.2 | 378.8 | 206.2 |
| 16 | Цахир сум | 106.3 | 17 | 271.2 | 217.3 | 205.5 | 118.3 |
| 17 | Хашаат | 65.8 | 12 | 339.0 | 274.5 | 258.9 | 80.6 |
| 18 | Эрдэнэмандал | 177.1 | 13 | 744.4 | 583.0 | 589.7 | 170.5 |
| 19 | Жаргалант | 310.4 | 26 | 411.4 | 305.0 | 373.3 | 242.1 |
| | Сумдын дүн | 1,727.00 | 415 | 10,129.3 | 7,392.6 | 7,183.0 | 1,936.70 |
| 1 | Аймгийн дүн | 1,249.40 | 32 | 5,976.2 | 4,949.1 | 5,043.4 | 1,155.10 |
| | НИЙТ | 2,976.40 | 447 | 16,105.5 | 12,341.7 | 12,226.4 | 3,091.80 |

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ тогтоол, ОНХС-ийн тайлан

Өмнөх оны аудитаар нийт 5,185.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 5,029.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах 38, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 155.1 сая төгрөгийн 4 зөвлөмжийг аймаг сумдын Засаг дарга нарт хүргүүлж биелэлтийг хангуулсан байна. ОНХС-ийн мэдээллийг иргэдэд үнэн зөв, түргэн шуурхай хүргэх зорилгоор ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс санхүүжүүлсэн




Сангийн яамны сайтад байршуулсан “Удирдлагын мэдээллийн систем”-д оруулахаар заажээ.¹

Харин удирдлагын мэдээллийн системд оруулсан 2023 оны мэдээллийг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөр нэгтгэхэд 2023 онд аймгийн хэмжээнд 274 ажлын гүйцэтгэл 100 хувь, үүнээс тайлант онд ашиглалтад орох 250 ажил байна. /Эх сурвалж: ОНХС-ын Удирдлагын мэдээллийн систем/

2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга, хэмжээг ангилан харуулбал дараах байдалтай байна.

Дүрслэл 1.



Графикаас харахад: 2023 онд барилга байгууламжид 14 хувь буюу 1,704.4 сая, их засварт 0.1 хувь буюу 11.8 сая, тоног төхөөрөмжид 2.1 хувь буюу 256.7 сая, бусад хөрөнгөд 83.8 хувь буюу 10,171.5 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Аудитын тайланг дэд зорилтоор бүлэг болгон танилцуулж байна.

¹ “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.5 “ОНХС-ийн УМС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт цэсэд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулах”,



БҮЛЭГ 1. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА

1.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД 831.0 САЯ ТӨГРӨГИЙН ОРЛОГЫГ БҮРДҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

1.1.1. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 169.1 сая төгрөгөөр дутуу олгосон байна

Төсвийн тухай хуулийн 59.1²-д заасны дагуу 2023 оны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санг /ОНХНС/ төлөвлөж, тус сангаас Архангай аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар анх 8,580.8 сая төгрөгөөр баталсныг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 2,159.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 10,740.4 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

Хүснэгт №2 ОНХС-ийн төлөвлөлт

/сая төгрөгөөр/

| ОНХС-ийн орлогын эх үүсвэр | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|--|---|-----------------|-----------------|--------------|
| ОНХНС-аас ОНХС-д олгох орлогын шилжүүлэг | Газрын тосны нөөц ашигласны төлбөр -30% | 498.5 | 354.0 | 144.5 |
| | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр -10% | 9,604.8 | 9,604.8 | 0.0 |
| Улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлэг | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр - 100 % | 8.4 | 7.7 | 0.7 |
| | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр - 50% | 124.6 | 100.7 | 23.9 |
| Олон улсын байгууллагаас сумдын ОНХС-д олгох урамшуулал | | 504.1 | 504.1 | 0.0 |
| Аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн нийт дүн | | 10,740.4 | 10,571.3 | 169.1 |

Эх сурвалж: Сангийн Яам, аймгийн СТСХ

ОНХС-ийн санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвөөс 10,236.3 сая төгрөг, “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс 504.1 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр газрын тосны нөөц ашигласны төлбөр 144.4 сая төгрөг, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 0.8 сая төгрөг, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 23.9 сая төгрөгөөр дутуу төвлөрснөөс шалтгаалж, аймагт 169.1 сая төгрөгөөр дутуу буюу 10,571.3 сая төгрөгийн орлогыг шилжүүлсэн байна.

Архангай аймагт 2022 онд ОНХНС-аас 6,815.9 сая төгрөгийн төлөвлөн олгож байсан бол 2023 онд төсвийн тодотголоор 10,740.4 сая төгрөг байхаар төлөвлөсөн нь өмнөх оноос 57.6 хувь буюу 3,924.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль журмаар баталсан аргачлалын дагуу хуваарилж олгосон байна

Сангийн яам ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 59.3 дахь заалтууд, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоол “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу

² 59.1.2.Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь, 59.1.3.орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг; 59.1.5 газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.



хүн амын тоо, нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ зэрэг шалгуур үзүүлэлтэд үндэслэн тооцсон байна.

ОНХС-ийн суурь тооцооллыг сумдаар авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №3 ОНХС-ийн суурь тооцоолол

/сая төгрөгөөр/

| Сумын нэр | Итгэлцүүрээр хуваарилсан дүн | Урамшуулал | АМХТЗТ /сумдад хуваарилах суурь 50 хувь/ | АМАТЗТ /сумдад хуваарилах суурь 50 хувь/ | Сумдын ОНХС-д хуваарилагдах суурь дүн |
|---------------------------|------------------------------|--------------|--|--|---------------------------------------|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5=1+2+3+4 |
| Ихтамир сум | 277.7 | | - | 0.5 | 278.3 |
| Чулуут сум | 281.6 | | - | 1.0 | 282.6 |
| Хангай сум | 312.3 | 40.4 | - | - | 352.7 |
| Тариат сум | 333.6 | 43.3 | 0.1 | 0.5 | 377.4 |
| Өндөр-Улаан сум | 360.3 | 47.2 | - | - | 407.4 |
| Эрдэнэмандал сум | 362.4 | | - | - | 362.4 |
| Жаргалант сум | 332.4 | 44.3 | - | - | 376.7 |
| Цэцэрлэг сум | 281.2 | | - | - | 281.2 |
| Хайрхан сум | 253.2 | 33.9 | - | - | 287.1 |
| Батцэнгэл сум | 220.2 | 29.1 | 1.7 | 4.5 | 255.6 |
| Өлзийт сум | 194.4 | 30.5 | - | 0.5 | 225.3 |
| Өгийнуур сум | 161.9 | 26.2 | 0.4 | - | 188.5 |
| Хашаат сум | 227.6 | 36.2 | 0.9 | - | 264.7 |
| Хотонт сум | 224.5 | | - | - | 224.5 |
| Цэнхэр сум | 245.4 | 31.8 | 1.1 | 34.6 | 312.9 |
| Төвшрүүлэх сум | 115.8 | 15.9 | - | 20.7 | 152.3 |
| Булган сум | 163.9 | 21.3 | - | - | 185.2 |
| Эрдэнэбулган сум | 460.9 | 72.7 | - | - | 533.7 |
| Цахир сум | 242.4 | 31.5 | - | - | 273.9 |
| Сумдын дүн -50% | 5,051.6 | 504.1 | 4.2 | 62.3 | 5,622.2 |
| Аймагт хуваарилагдсан-50% | 5,118.2 | - | - | - | 5,118.2 |
| Нийт дүн | 10,169.8 | 504.1 | 4.2 | 62.3 | 10,740.4 |

Эх сурвалж: Сангийн Яам, аймгийн СТСХ

Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д нийт 5,622.3 сая төгрөгийг МУЗГ-ын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал"-ын дагуу орлогын шилжүүлгийн суурь тооцооллоор хуваарилсан байна. Үүнд: сумдад итгэлцүүрээр олгох 5,051.6 сая төгрөг, урамшуулал 504.1 сая төгрөг, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50% болох 4.2 сая төгрөг, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50% болох 62.3 сая төгрөг байна.

Харин аймгийн ОНХС-д 5,118.2 сая төгрөгийг аргачлалын дагуу хуваарилжээ.

ОНХНС болон улсын төсвөөс Архангай аймгийн ОНХС-д орлогын шилжүүлгийг батлагдсан санхүүжилтийн хуваарийн дагуу дараах байдлаар олгосон байна.

Хүснэгт №4 ОНХНС-аас аймагт олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

| Санхүүжилт улирлаар | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|------------------------------|------------|-----------|--------|
| 1-р улиралд олгох санхүүжилт | 1,390.1 | 1,373.2 | 16.9 |
| 2-р улиралд олгох санхүүжилт | 2,931.5 | 2,748.4 | 183.1 |
| 3-р улиралд олгох санхүүжилт | 3,209.4 | 3,255.4 | (46.0) |
| 4-р улиралд олгох санхүүжилт | 3,209.4 | 3,194.3 | 15.1 |
| Нийт | 10,740.4 | 10,571.3 | 169.1 |



Эх сурвалж: Сангийн Яам, аймгийн СТСХ

Хүснэгтээс харахад ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг 169.1 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн нь ОНХНС болон улсын төсвийг бүрдүүлж буй татварын орлогын бүрдүүлэлтээс хамаарсан байна. Тухайлбал: газрын тосны нөөц ашигласны төлбөр 144.4 сая төгрөг, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 0.8 сая төгрөг, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого 23.9 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн нь нөлөөлсөн байна.

1.1.3. Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгосон байна

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Аймгийн ИТХ-ын 2023 оны 6 дугаар сарын 27-ний өдрийн “Аймгийн 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 17 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны 06 дугаар сарын өдрийн “Төсвийн хуваарь батлах тухай” 01/4781 дугаар тушаалд үндэслэн Аймгийн засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 19-ны А/480 дугаар захирамжаар ОНХС-ийн сар, улирлын хуваарийг баталсан байна. Батлагдсан хуваарийн дагуу аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт олгосон байдлыг улирлаар нэгтгэн авч үзвэл:

Хүснэгт № 5 Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт

/сая төгрөгөөр/

| Санхүүжилт улирлаар | Аймаг, сум | Сар, улирлын санхүүжилтийн хуваарь | Гүйцэтгэл | Зөрүү |
|---------------------|------------|------------------------------------|-----------------|--------------|
| 1-р улирал | Аймаг | 695.1 | 695.1 | - |
| | Сумд | 695.1 | 695.1 | - |
| | Нийт | 1,390.2 | 1,390.2 | - |
| 2-р улирал | Аймаг | 1,213.7 | 1,213.7 | - |
| | Сумд | 1,717.9 | 1,717.9 | - |
| | Нийт | 2,931.6 | 2,931.6 | - |
| 3-р улирал | Аймаг | 1,613.6 | 1,613.6 | - |
| | Сумд | 1,595.6 | 1,595.6 | - |
| | Нийт | 3,209.2 | 3,209.2 | - |
| 4-р улирал | Аймаг | 1,595.7 | 1,426.6 | 169.1 |
| | Сумд | 1,613.7 | 1,613.7 | - |
| | Нийт | 3,209.4 | 3,040.3 | 169.1 |
| Нийт | Аймаг | 5,118.1 | 4,949.0 | 169.1 |
| | Сумд | 5,622.3 | 5,622.3 | - |
| | Нийт | 10,740.4 | 10,571.3 | 169.1 |

Эх сурвалж: Аймгийн СТСХ

Хүснэгтээс харахад сумдад хуваарийн дагуу санхүүжилтийг бүрэн олгож, аймгийн ОНХС нь 169.1 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

1.1.4. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасан эх үүсвэрээс бүрдүүлэхээр төлөвлөсөн боловч 831.0 сая төгрөгийн орлогыг санд дутуу төвлөрүүлсэн байна.

Аймаг, сумдын ИТХ-аас ОНХС-ийн 2023 оны эх үүсвэрт ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгээс 10,740.4 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 1,798.8 сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар³ 240.0 сая төгрөг,

³ Төсвийн тухай хуулийн 60.2.4. татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;



малын тоо толгойн албан татвараас⁴ 3,326.3 сая төгрөг, нийт 16,105.5 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөж баталсан байна.

Хүснэгт №6 Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт

/сая төгрөгөөр/

| Сумын нэр | 2023 оны ОНХС болон улсын төсвөөс | | | | 2023 оны Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр | | | ОНХС-ийн нийт эх үүсвэр |
|------------------|---|---|---|---|--|---|--------------------------------|-------------------------|
| | ОНХС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг /ТТХ-ийн 60.2.1/ | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 100% /ТТХ-ийн 60.2.7/ | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 50% /ТТХ-ийн 60.2.7/ | "Тогтвортой амжиргаа-3" төсөл урамшуулал /ТТХ-ийн 59.1.3/ | ИТХ-ын тогтоолоор баталсан ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл | ТТХ-ийн 60.2.4 Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр /ТТХ-ийн 60.2.4/ | Малын тоо толгойн албан татвар | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8=1+2+3+4+5+6+7 |
| Ихтамир сум | 277.7 | - | - | 0.5 | 18.2 | - | 275.8 | 572.3 |
| Чулуут сум | 281.6 | - | - | 1.0 | 37.8 | - | 159.5 | 479.9 |
| Хангай сум | 312.3 | 40.4 | - | - | 57.7 | - | 58.4 | 468.8 |
| Тариат сум | 333.6 | 43.3 | 0.1 | 0.5 | 79.0 | - | 210.5 | 666.9 |
| Өндөр-Улаан сум | 360.3 | 47.2 | - | - | 39.8 | - | 244.3 | 691.5 |
| Эрдэнэмандал сум | 362.4 | - | - | - | 40.7 | - | 419.7 | 822.8 |
| Жаргалант сум | 332.4 | 44.3 | - | - | 244.1 | - | 307.3 | 928.1 |
| Цэцэрлэг сум | 281.2 | - | - | - | 20.0 | - | 77.6 | 378.8 |
| Хайрхан сум | 253.2 | 33.9 | - | - | 22.9 | - | 221.6 | 531.6 |
| Батцэнгэл сум | 220.2 | 29.1 | 1.7 | 4.5 | 107.9 | - | 130.5 | 494.0 |
| Өлзийт сум | 194.4 | 30.5 | - | 0.5 | 23.6 | - | 184.3 | 433.2 |
| Өгийнуур сум | 161.9 | 26.2 | 0.4 | - | 64.3 | - | 111.2 | 364.0 |
| Хашаат сум | 227.6 | 36.2 | 0.9 | - | 65.0 | - | 64.0 | 393.7 |
| Хотонт сум | 224.5 | - | - | - | 61.6 | - | 372.3 | 658.4 |
| Цэнхэр сум | 245.4 | 31.8 | 1.1 | 34.6 | 14.0 | - | 152.5 | 479.4 |
| Төвшрүүлэх сум | 115.8 | 15.9 | - | 20.7 | 16.0 | - | 102.9 | 271.2 |
| Булган сум | 163.9 | 21.3 | - | - | 55.7 | - | 98.1 | 339.0 |
| Эрдэнэбулган сум | 460.9 | 72.7 | - | - | 123.9 | - | 86.9 | 744.5 |
| Цахир сум | 242.4 | 31.5 | - | - | 88.6 | - | 48.9 | 411.4 |
| Сумдын дүн | 5,051.6 | 504.1 | 4.2 | 62.3 | 1,180.8 | - | 3,326.3 | 10,129.3 |
| Аймаг | 5,051.7 | - | 4.2 | 62.3 | 618.0 | 240.0 | - | 5,976.2 |
| Нийт | 10,103.3 | 504.1 | 8.4 | 124.6 | 1,798.8 | 240.0 | 3,326.3 | 16,105.5 |

Аймгийн онцлог нөхцөл байдалтай уялдуулан орон нутгийн суурь болон нийт орлогын зөрүүгээр аймгийн ОНХС-д дараах татварын орлогын хувь хэмжээг 240.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна. Үүнд:

- Бичил худалдааны татвар 0.2 сая төгрөг
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг 30.0 сая төгрөг
- Улсын тэмдэгтийн хураамжийг 20.0 сая төгрөгөөр
- Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 79.0 сая төгрөгөөр
- Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг 28.9 сая төгрөг
- Газрын төлбөр 81.9 сая төгрөг

Аудитын илрүүлэлт:

⁴ Төсвийн тухай хуулийн 60.2.8.малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.



- ✓ Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар аймгийн ОНХС-д бүрдүүлэхээр 240.0 сая төгрөгийг төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр аймгийн ОНХС-д төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1⁵ дэх заалтыг зөрчсөн байна.

Аудитаас татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон эх үүсвэрээс аймгийн ОНХС-д 240.0 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн зөрчлийг арилгах орлогыг бүрэн төвлөрүүлэх албан шаардлагыг албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Малын тоо толгойн албан татварын 2022 оны орлогыг 19 сумын хэмжээнд нийт 2,348.9 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 1,757.9 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлт 74.8 хувь буюу 591.0 сая төгрөгийн орлого тасарсан байна. Үүний улмаас сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна.

Аймгийн хэмжээнд 2022, 2023 онуудад дараалан өвөлжилт хүндэрч, гамшгийн улмаас мал сүрэг олноор хорогдож, малчдын амьжиргааны түвшинд нөлөөлсөнтэй холбогдуулан 4 сумын ИТХ-аар малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээг “0” төгрөгөөр баталж, Хууль зүй, дотоод хэргийн ямаар хянуулан зөвшөөрөгдсөн байна. Үүний улмаас 2024 онд 793.8 сая төгрөгийн орлогыг сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх боломжгүй болсон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 заалттай зөрчилдөж байна.

1.2. АЙМАГ, СУМЫН ЗДТГ НЬ ИРГЭДИЙН САНАЛ АВААГҮЙ 67 ТАХ-Г ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН БАЙНА

1.2.1. Аймгийн хэмжээнд иргэдийн санал аваагүй 67 ТАХ-ийг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан нь нийт ТАХ-ний 14.9 хувийг эзэлж байна

Аймгийн хэмжээнд 2023 онд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр нийт 16,105.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 447 төсөл арга хэмжээг төлөвлөж баталсан байна. Үүнийг Төсвийн тухай хуулийн 60.3.6⁶, “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2⁷-д заасны дагуу орон нутгийн иргэдийн саналд үндэслэн төлөвлөсөн эсэхийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

Дүрслэл 2. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын санал авсан, эрэмбэлсэн байдал /сая.төг/

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх баталсан 5,976.1 сая төгрөгийн 32 төсөл арга хэмжээ нь урьдчилсан саналын жагсаалтыг боловсруулж, нээлттэй хэлэлцүүлэг хийж төлөвлөөгүй.
- Аймгийн 19 сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 10,129.4 сая төгрөгийн 415 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөсний 9,457.7 сая төгрөгийн 380 ТАХ нь иргэдийн саналд үндэслэсэн бол 671.7 сая төгрөгийн 35 нь иргэдийн санал аваагүй ТАХ байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №1 –ээс үзнэ үү)



Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх ТАХ-ийн саналыг давхардсан тоогоор 83,741 иргэнээс авсан байна. Иргэдээс 20,919.9 сая төгрөгийн 655 ТАХ-г

⁵ 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;

⁶ 60.3.6. орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

⁷ 4.3.2.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;



хэрэгжүүлэх санал гарснаас 15,433.8 сая төгрөгийн 432 ТАХ-г хэрэгжүүлэхээр, иргэдийн саналгүй 671.7 сая төгрөгийн 35 төсөл арга хэмжээг төлөвлөн сумын ИТХ-аар баталсан байна. Мөн 4,814.4 сая төгрөгийн 208 ТАХ цуцлагдсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлтөд иргэдийн саналыг эрэмбэлсэн байдлыг авч үзвэл 19 сумын сонгуулийн насны нийт иргэдийн 23 хувь буюу 14,196 иргэн саналаа өгсөн нь хангалтгүй байна. Эндээс харахад ОНХС-ийн төлөвлөх үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог бүрэн хангаагүйн улмаас олонхийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ТАХ-г төлөвлөж хэрэгжүүлдэггүй, нөгөө талаас иргэдийн ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцох идэвх оролцоо сул байна.

Аймгийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2013-2023 оны байдлаар 62,574.0 сая төгрөгийн 2191 төсөл, арга хэмжээ хэрэгжсэнээс 30.6 хувь буюу 19,136.7 сая төгрөгийг барилга байгууламжид, 18.1 хувь буюу 11,317.2 сая төгрөгийг машин, тоног төхөөрөмжид, 19.1 хувь буюу 11,981.6 сая төгрөгийг их засвар, тохижилтод, 32.2 хувь буюу 20,138.5 сая төгрөгийг бусад буюу урсгал зардалд зарцуулжээ. Үүнээс үзэхэд 51.3 хувь буюу 32,120.1 сая төгрөгийг их засвар, тохижилт, урсгалд зарцуулсан нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцлийг бүрдүүлэх зорилготой сангийн хөрөнгийн мөн чанар үр нөлөө буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Аймгийн ОНХС: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 5,976.1 сая төгрөгийн 32 төсөл арга хэмжээнд урьдчилсан саналын жагсаалтыг боловсруулж, иргэд олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж төлөвлөөгүй ИТХ-аар баталсан.
- ✓ Сумдын ОНХС: Жаргалант сум 175.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11, Хайрхан сум 145.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5, Цэцэрлэг сум 157.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6, Чулуут сум 178.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11, Эрдэнэбулган сум 15.0 сая төгрөгийн 2 нийт **671.7** сая төгрөгийн төсөвт өртөгтэй **35** ТАХ-г иргэдийн санал аваагүй төлөвлөсөн байна.


Аудитаар иргэдийн саналд тусгагдаагүй төсөл арга хэмжээг төлөвлөж, баталсан зөрчлийг таслан зогсоох, Төсвийн тухай хуулийн 60.3.6, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2-т заасныг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймаг, сумын Засаг дарга нарт хүргүүлээ.

Аудитын явцад ОНХС-ийн үйл ажиллагааны талаар иргэд олон нийтээс цаасан болон цахимаар авсан санал асуулгад 739 иргэн хамрагдсаны 60 хувь нь ОНХС-ийн талаарх мэдээлэл хангалтгүй, мэдэхгүй гэж хариулсан бол 64 хувь нь ОНХС-ийн холбогдох хууль тогтоомж, журмыг судлаагүй гэсэн хариултыг өгсөн байна.

Харин 46 хувь нь ОНХС-аар хэрэгжүүлэх ТАХ-нд саналаа өгөөгүй, 34 хувь нь 2023 онд хэрэгжсэн ТАХ-ний талаар мэдээлэлгүй гэж хариулсан байна.

Санал асуулгын дүнгээс гол үзүүлэлтүүдийг нэгтгэн графикаар харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Дүрслэл 3. Иргэдээс авсан санал асуулгын дүнгийн нэгтгэл



Иргэд олон нийтээс авсан дээрх санал асуулгын дүн аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийхэд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний талаар иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй, хөдөлмөрийн насны иргэдийн санал төлөөлөхүйц хангалттай түвшинд хүрээгүй байна. Энэ нь нэг талаас бодлого хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтны зүгээс тус сангийн мэдээллийг иргэд олон нийтэд ил тод хүргэх, тайлагнах, танилцуулах байдал дутмаг, нөгөө талаас ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцох иргэдийн идэвх оролцоо сул байгаатай холбоотой байна. Иймд иргэдэд ОНХС-ийн талаарх мэдээлэл түгээх үйл ажиллагааг үр дүнтэй арга хэлбэрээр зохион байгуулж иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Аудитын дүнд үндэслэн аймгийн ИТХ-ын даргад иргэдээс санал аваагүй ТАХ-г ИТХ-аар батлахгүй байх зөвлөмжийг хүргүүлээ.

1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт ТАХ-ний 98.2 хувь нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.4⁸ дэх заалттай нийцсэн байх шаардлагатай.

Үүний дагуу аймгийн хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 447 ТАХ-г аймаг, сумын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон аймаг, сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа мөрийн хөтөлбөртэй уялдуулан үзэхэд

⁸ орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх



15,575.7 сая төгрөгийн 439 ТАХ нь уялдсан бол 529.8 сая төгрөгийн 8 ТАХ нь уялдаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 529.8 сая төгрөгийн 8 ТАХ нь (дэлгэрэнгүйг хавсралт №2-оос үзнэ үү) аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй нь Сангийн сайдын 2021 оны 86 тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7 дугаар зүйлийн 7.3.1⁹, 7.3.2¹⁰ дахь заалттай нийцэхгүй байна.

Аудитаас Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй ТАХ-г төлөвлөсөн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

1.2.3. Төсвийн тухай хуулийг зөрчиж, төсөвлөлтийн шаардлага хангаагүй 6,924.6 сая төгрөгийн 75 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт **16,105.5** сая төгрөгийн **447** төсөл, арга хэмжээнээс ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгавар, урсгал зардлын урьдчилсан тооцоолол хийгээгүй нийт **6,924.6** сая төгрөгийн **75** ТАХ байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹¹ дэх заалттай нийцэхгүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №3-аас үзнэ үү)

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ОНХС: ТЭЗҮ, зураг төсөвгүй, үр ашгийн урьдчилсан тооцоолол хийгээгүй, төсөвт үзүүлэх ачааллыг урьдчилж тооцоогүй 5,976.1 сая төгрөгийн 32 ТАХ,
- Тариат сумын ОНХС: ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй 602.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 ТАХ,
- Цахир сумын ОНХС: ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй 346.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан.

Аудитаар Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага, шалгуур хангаагүй ТАХ-г төлөвлөсөн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх шаардлагыг аймаг, сумын Засаг даргад хүргүүллээ.

1.2.4. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 16,105.5 сая төгрөгийн 447 ТАХ нь журамд заасан чиг үүрэгтэй уялдаж байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 447 төсөл арга хэмжээнд 16,105.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 352 ТАХ-нд 12,226.4 сая төгрөг зарцуулсныг Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-д заасан чиг үүрэгтэй уялдуулан шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 24 ТАХ-г төлөвлөсөн нь журамд заасан чиг үүрэгтэй нийцэж байгаа бөгөөд 54.2 хувь буюу 13 ТАХ нь "Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ", 16.7 хувь буюу 4 ТАХ нь "Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн

⁹ 7.3.1. Тухайн аймаг, нийслэлийн хөгжлийн бодлого чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөө;

¹⁰ 7.3.2. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ;

¹¹ "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана"



чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх” чиг үүргийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь нийт ТАХ-ний 70.9 хувийг эзэлж байна.

Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг журамд заасан чиг үүргээр ангилан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 7. Аймгийн ОНХС-ийн чиг үүрэг

/сая.төгрөг/

| Журамд заасан чиг үүрэг | ТАХ | Олгосон санхүүжилт /сая төгрөг/ | Хувь |
|---|-----------|---------------------------------|--------------|
| 4.2.1. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи; | 1 | 10.0 | 4.2 |
| 4.2.2. Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ; | 13 | 2,868.2 | 54.2 |
| 4.2.3. Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах; | 1 | 196.7 | 4.2 |
| 4.2.4. Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах; | 1 | 113.9 | 4.2 |
| 4.2.5. Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах; | 1 | 557.8 | 4.2 |
| 4.2.6. Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх | 4 | 1,010.4 | 16.7 |
| 4.2.8. Ажлын байр бий болгох; | 2 | 271.4 | 8.3 |
| 4.7.2. Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн ёслолын зардал; | 1 | 15.0 | 4.2 |
| Нийт дүн | 24 | 5,043.4 | 100.0 |

- Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 328 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс журмын 4.4.3-д "Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах" чиг хэрэгжүүлэхэд 24.7 хувь буюу 81 ТАХ, "Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ" чиг үүргийг хэрэгжүүлэхэд 21.3 хувь буюу 70 ТАХ-г төлөвлөсөн нь нийт ТАХ-ний 46 %-ийг эзэлж байна

Хүснэгт 8. Сумдын ОНХС-ийн чиг үүрэг

/сая.төгрөг/

| Журамд заасан чиг үүрэг | ТАХ | Олгосон санхүүжилт /сая төгрөг/ | Хувь |
|---|-----|---------------------------------|------|
| 4.4.1. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи; | 28 | 691.3 | 8.5 |
| 4.4.2. Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ; | 70 | 2,138.2 | 21.3 |
| 4.4.3. Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах; | 81 | 1,716.4 | 24.7 |
| 4.4.4. Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах; | 18 | 423.0 | 5.5 |
| 4.4.5. Сум, дүүргийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах; | 8 | 88.2 | 2.4 |
| 4.4.6. Мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах; | 2 | 47.9 | 0.6 |
| 4.4.7. Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт; | 1 | 6.4 | 0.3 |
| 4.4.8. Ажлын байр бий болгох; | 6 | 458.0 | 1.8 |
| 4.4.9. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа. | 1 | 6.0 | 0.3 |
| 4.5.1. Бэлчээрийн менежментийг сайжруулах; | 15 | 199.6 | 4.6 |
| 4.5.2. Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах/ | 2 | 36.0 | 0.6 |
| 4.5.3. Малын эрүүл мэндийг хамгаалах; | 9 | 69.1 | 2.7 |
| 4.5.4. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх; | 19 | 377.0 | 5.8 |



| | | | |
|--|------------|-----------------|--------------|
| 4.5.5.Малын чанарыг сайжруулах; | 5 | 38.9 | 1.5 |
| 4.5.6.Гэмт халдлага, гамшгаас хамгаалах; | 5 | 46.7 | 1.5 |
| 4.5.7.Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх; | 1 | 6.0 | 0.3 |
| 4.5.8.Малын тэжээлийн ургамал тариалах; | 5 | 94.7 | 1.5 |
| 4.5.9.Тэжээлийн нөөц бүрдүүлэх; | 12 | 234.6 | 3.7 |
| 4.5.10.Байгаль орчныг хамгаалах; | 9 | 125.6 | 2.7 |
| 4.5.11.Хортон мэрэгчидтэй тэмцэх/байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/; | 4 | 100.5 | 1.2 |
| 4.5.12.Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа. | 11 | 88.0 | 3.4 |
| 4.7.2.Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн ёслолын зардал; | 16 | 190.8 | 4.9 |
| Нийт дүн | 328 | 7,182.90 | 100.0 |

БҮЛЭГ 2. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН НИЙТ ТАХ-НИЙ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ, АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БАРИМТЛААГҮЙ БАЙНА.

2.1.1. Шинээр хэрэгжүүлсэн нийт ТАХ-ний 68.9 хувь нь 20.0 сая төгрөгөөс доош шууд гэрээ байгуулахаар хэт жижиглэн төлөвлөсөн байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд шинээр нийт 11,684.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 344 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс 8,699.1 сая төгрөгийн 107 төсөл, арга хэмжээ нь журамд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тогтоосон босго үнээс доош дүнтэй 2,985.6 сая төгрөгийн 237 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулахаар төлөвлөсөн байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг авч үзвэл:

Дүрслэл 4. Худалдан авах ажиллагаа



- **Нээлттэй тендер шалгаруулалтаар** 4,811.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 21 төсөл арга хэмжээ,
- **Харьцуулалтын аргаар** 3,228.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 73 төсөл арга хэмжээг
- **Онцгой нөхцөлд гэрээ шууд байгуулсан** 325.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээг
- **Олон нийтийн оролцоотой худалдан авалтаар** 80.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл арга хэмжээг
- **Хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар** 253.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээг тус тус зохион байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ **Цахир сум:** Сумын Засаг дарга ЗДТГ-ын няравтай шууд гэрээ байгуулж баяр наадмын зардалд 20.0 сая төгрөгийг нярвын данс руу шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитаас дээрх зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах албан шаардлагыг Цахир сумын Засаг даргад хүргүүлээ.



2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бус, урсгал шинжтэй үйл ажиллагаанд зарцуулж байна

Аймгийн хэмжээнд тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 447 төсөл арга хэмжээнд **16,105.5** сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 74.5 хувь буюу 11,501.8 сая төгрөгийн 333 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн ба 1,336.8 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээ хэрэгжих шатандаа байна. Харин өвөлжилт хүндэрч, Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт 46.8 хувь буюу 1,556.0 сая төгрөгөөр тасарсан, зарим ТАХ-ний худалдан авах ажиллагаа амжилтгүй болсноос шалтгаалж 3,226.0 сая төгрөгийн 95 төсөл, арга хэмжээ нь хэрэгжээгүй байна.

Хүснэгт 9. ОНХС-ийн 2023 оны хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилт

| № | Аймаг, сумын нэр | ИТХ-аар батлагдсан ХО, хөтөлбөр, ТАХ-ний тоо | Бүрэн хэрэгжсэн хөрөнгө оруулалт | | Дутуу хэрэгжсэн хөрөнгө оруулалт | | Огт хэрэгжээгүй хөрөнгө оруулалт | |
|----|------------------|--|----------------------------------|-------------|----------------------------------|-------------|----------------------------------|--------------|
| | | | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| 1 | Ихтамир сум | 21 | 11 | 52.4 | 2 | 9.5 | 8 | 38.1 |
| 2 | Чулуут сум | 29 | 27 | 93.1 | - | - | 2 | 6.9 |
| 3 | Хангай сум | 15 | 11 | 73.3 | 1 | 6.7 | 3 | 20 |
| 4 | Тариат сум | 34 | 27 | 79.4 | 2 | 5.9 | 5 | 14.7 |
| 5 | Өндөр-Улаан сум | 34 | 24 | 70.6 | 4 | 11.8 | 6 | 17.6 |
| 6 | Эрдэнэмандал сум | 40 | 34 | 85 | - | - | 6 | 15 |
| 7 | Жаргалант сум | 37 | 30 | 81.1 | 1 | 2.7 | 6 | 16.2 |
| 8 | Цэцэрлэг сум | 20 | 17 | 85 | - | - | 3 | 15 |
| 9 | Хайрхан сум | 18 | 13 | 72.2 | - | - | 5 | 27.8 |
| 10 | Батцэнгэл сум | 20 | 13 | 65 | - | - | 7 | 35 |
| 11 | Өлзийт сум | 20 | 17 | 85 | - | - | 3 | 15 |
| 12 | Өгийнуур сум | 10 | 6 | 60 | - | - | 4 | 40 |
| 13 | Хашаат сум | 15 | 13 | 86.7 | - | - | 2 | 13.3 |
| 14 | Хотонт сум | 20 | 11 | 55 | - | - | 9 | 45 |
| 15 | Цэнхэр сум | 14 | 10 | 71.4 | - | - | 4 | 28.6 |
| 16 | Төвшрүүлэх сум | 17 | 13 | 76.5 | - | - | 4 | 23.5 |
| 17 | Булган сум | 12 | 8 | 66.7 | - | - | 4 | 33.3 |
| 18 | Эрдэнэбулган сум | 13 | 7 | 53.8 | 3 | 23.1 | 3 | 23.1 |
| 19 | Цахир сум | 26 | 21 | 80.8 | 2 | 7.7 | 3 | 11.5 |
| 20 | Аймаг | 32 | 20 | 62.5 | 4 | 12.5 | 8 | 25 |
| | нийт дүн | 447 | 333 | 74.5 | 19 | 4.25 | 95 | 21.25 |

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 4 ТАХ-ний ажлын бодит гүйцэтгэлд үндэслээгүй зориулалт бус, урсгал шинжтэй үйл ажиллагаанд 175.2 сая төгрөгийг зарцуулсан дараах зөрчил илэрлээ. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- ✓ Аймгийн ОНХС: “Ус цаг уур, орчны шинжилгээний төв”-ийн конторын барилгын засвар, өргөтгөлийн барилгын зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчтэй 20.0 сая төгрөгийн өртөгтэй гэрээ байгуулсан ч гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй байхад 18.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон
- ✓ Эрдэнэбулган сумын ОНХС: 170.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Явган хүний зам тавих" ажлын бодит гүйцэтгэл 70 хувьтай гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байхад 135.2 сая төгрөг буюу 79 хувийн санхүүжилт олгосон
- ✓ Ихтамир сумын ОНХС: 19.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн хэсэгчилсэн камер тавих, засварлах ажлын гүйцэтгэгч "ГЦ Гоулд дизайн" ХХК нь гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй байхад санхүүжилтийг 100 хувь олгосон




- ✓ Өндөр-Улаан сумын ОНХС: Малчдын зөвлөгөөний хүрээнд сургагч багшийн төлбөр болон шагналын 2.5 сая төгрөгийг нярвын данс руу шилжүүлж зориулалт бус зарцуулсан

ОНХС-ийн хөрөнгийг ажлын бодит гүйцэтгэлд үндэслэхгүйгээр санхүүжилт олгосон, зориулалт бус, урсгал шинжтэй үйл ажиллагаанд зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх, таслан зогсоох холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах албан шаардлагыг аймгийн болон холбогдох сумын Засаг дарга нарт хүргүүллээ.

2.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАХ-НИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.2.1. Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн нийт ТАХ-ний 10.2 хувь нь төлөвлөсөн зорилтод үр дүнд хүрээгүй байна

Дүрслэл 5. Зорилтот түвшинд хүрсэн байдал



Аймгийн хэмжээнд бүрэн хэрэгжсэн 11,501.8 сая төгрөгийн 333 төсөл, арга хэмжээнээс 10,743.9 сая төгрөгийн 299 төсөл, арга хэмжээ буюу 89.8 хувь нь төлөвлөсөн зорилтод түвшинд хүрсэн бол 811.4 сая төгрөгийн 34 төсөл, арга хэмжээ буюу 10.2 хувь нь зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Аудитаар төлөвлөсөн зорилтот үр дүн, үр ашигт хүрээгүй 811.4 сая төгрөгийн 34 төсөл, арга хэмжээтэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- ✓ Тариат сумын ОНХС: 53.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан актгүй, гэрээг дүгнээгүй байхад санхүүжилтийг 100 хувь олгож, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг үнэлээгүй.
- ✓ Цахир сумын ОНХС: Бүрэн хэрэгжсэн 20 төсөл арга хэмжээнээс 310.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнээгүй байхад санхүүжилтийг 100 хувь олгож, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг үнэлээгүй.
- ✓ Эрдэнэбулган сумын ОНХС: 447.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнээгүй, төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхийг үнэлээгүй.

Аудитаас дээрх зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах албан шаардлагыг зөрчил гаргасан аймаг, Тариат, Цахир, Эрдэнэбулган сумын Засаг дарга нарт хүргүүллээ.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ-ний үр дүнд орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулсан байна

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд бүрэн хэрэгжсэн 11,501.8 сая төгрөгийн 333 төсөл, арга хэмжээнээс 96.9 хувь буюу 10,839.0 сая төгрөгийн 323 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод үр дүнд хүрсэн байна.



Орон нутгийн хөгжилд хувь нэмэр өгөхүйц бодит үр дүнтэй ажил болсон дараах төсөл, арга хэмжээнүүд байна. Тухайлбал:

САЙН ЖИШЭЭ:

- ✓ Хайрхан сум нь 2023 онд 29.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шүдний кабинет тохижуулалт”-ын ажлыг хэрэгжүүлснээр иргэдийн эрүүл мэндийг хамгаалсан, үр дүнтэй ажил болсон төдийгүй сумандаа шүдний эмчилгээ, үйлчилгээг ЭМДС-ийн хөнгөлөлттөөр хамрагдах боломжтой болсон байна.
- ✓ Өгийнуур сум нь 2023 онд 196.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын төвийн нутаг дэвсгэрт 540м урттай нэгдсэн халаалтын болон цэвэр усны дэд бүтэц”-ийн ажлыг гүйцэтгэснээр 25 айл өрх шугамын өргөтгөлд холбогдож байгаа цаашлаад 60 гаруй өрх холбогдохоор байгаа нь ард иргэд ая тухтай амьдрах нөхцөл бүрдсэн.
- ✓ Төвшрүүлэх сум нь 2023 онд 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн 2 худгийг ухаалаг системд холбох, тоног төхөөрөмж суурилуулах” ажлыг хэрэгжүүлснээр сумын төвийн 1200 иргэд 24 цагийн ундны усаар хангагдаж, сумын төсөвт 2024 оны 6 сарын байдлаар 6.6 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

2.3. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ, АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

2.3.1. Аймгийн хэмжээнд ОНХС-ын хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний **93.6** хувийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд аймгийн хэмжээнд нийт 11,501.8 сая төгрөгийн 333 төсөл арга хэмжээ хэрэгжүүлсэнээс 11,131.0 сая төгрөгийн 330 төсөл арга хэмжээний хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар хэвийн ашиглаж байна.

Хүснэгт №10 Хөрөнгийн ашиглалтын байдал /аймаг, сумдаар/ /сая төгрөг/

| № | Аймаг, сумын нэр | ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт | | | |
|----|------------------|---|-------|---|-----|
| | | Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж буй ТАХ | | Ашиглалтын явцад эвдрэл, гэмтэл гарсан, бүрэн хүчин чадлаар ашиглагдахгүй ТАХ | |
| | | тоо | дүн | тоо | дүн |
| 1 | Ихтамир сум | 11 | 434.8 | | |
| 2 | Чулуут сум | 27 | 360.9 | | |
| 3 | Хангай сум | 11 | 368.6 | | |
| 4 | Тариат сум | 27 | 561.4 | | |
| 5 | Өндөр-Улаан сум | 24 | 596.4 | | |
| 6 | Эрдэнэмандал | 33 | 760.2 | | |
| 7 | Жаргалант сум | 30 | 425.8 | | |
| 8 | Цэцэрлэг сум | 17 | 306.3 | | |
| 9 | Хайрхан сум | 13 | 339.0 | | |
| 10 | Батцэнгэл сум | 13 | 239.3 | | |
| 11 | Өлзийт сум | 17 | 292.3 | | |
| 12 | Өгийнуур сум | 6 | 290.8 | | |
| 13 | Хашаат сум | 13 | 359.2 | | |
| 14 | Хотонт сум | 11 | 313.3 | | |
| 15 | Цэнхэр сум | 10 | 384.8 | | |
| 16 | Төвшрүүлэх сум | 13 | 205.4 | | |
| 17 | Булган сум | 8 | 258.9 | | |
| 18 | Эрдэнэбулган сум | 6 | 332.4 | | |
| 19 | Цахир сум | 21 | 337.5 | | |



| | | | | |
|-----------------------|------------|-----------------|----------|--------------|
| сумын дүн | 314 | 7,535.4 | | 0 |
| Архангай аймгийн ОНХС | 16 | 3,595.6 | 3 | 370.8 |
| нийт дүн | 330 | 11,131.0 | 3 | 370.8 |

Дүрслэл 6.

Ашиглагч байгууллагын чанарын үнэлгээ

- Сайн
- Дүнд
- Хангалтгүй



ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 333 төсөл арга хэмжээгээр хэрэгжсэн хөрөнгийн ашиглагч байгууллагын чанарын үнэлгээ хийхэд 96.9 хувь нь ашиглалт сайн, 2.7 хувь нь ашиглалт дунд, 0.3 хувь нь ашиглалт муу байна.

Иргэд олон нийтээс авсан “Танай орон нутагт орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр бий болсон бүтээн байгуулалт, хөрөнгийн ашиглалтад та ямар үнэлгээ өгөх вэ” гэсэн асуумжид нийт 739 иргэн хамрагдаж 25.3 хувь буюу 187 сайн , 46.1 хувь буюу 341 дунд , 10 хувь буюу 76 хангалтгүй, 16.9 хувь буюу 125 мэдэхгүй гэж санал өгсөн байна.

Харин 370.8 сая төгрөгийн үнийн дүн бүхий 3 үндсэн хөрөнгө ашиглалтын явцад эвдэрч, гэмтэл гарсны улмаас ашиглалтыг зогсоосон байна.

Зураг-2 ХТҮГ-ын ковш



Зураг-1 Өлзийт сумын ЕБС-ийн хүнсний ногооны агуулах



Зураг-3 Цагдаагийн газрын шуурхай удирдлагын тасгийн тоног төхөөрөмж



Аудитын илрүүлэлт:

- ✓ **Аймгийн ОНХС:** Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд шинээр барьсан 75,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Өлзийт сумын ЕБС-ийн сургуулийн хүнсний ногооны агуулах нь ашиглалтын явцад мөөгөнцөр үүссэн, эвдрэл гэмтэл гарсны улмаас ашиглалтыг зогсоосон. /Зураг-1/
- ✓ **Аймгийн ОНХС:** Хот тохижилт үйлчилгээний газарт 148.8 сая төгрөгөөр худалдан авсан ковш нь эвдэрсний улмаас ашиглагдахгүй болсон. /Зураг-2/
- ✓ **Аймгийн ОНХС:** Аймгийн Цагдаагийн газрын шуурхай удирдлагын тасагт шилжүүлсэн 129.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдээс 8 дэлгэц чанарын шаардлага хангаагүй эвдрэл гэмтэл үүссэн ашиглалт хангалтгүй байна. /Зураг-3/

Аудитаас дээрх зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.



2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 420.3 сая төгрөгийн 10 ТАХ-ний хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжсэн 11,501.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 333 ТАХ-ээс 420.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ-нд ашиглагч иргэн, ААН-тэй түрээсийн гэрээ байгуулаагүй, төсөвт орлого төвлөрүүлээгүй, ашиглалт хангалтгүй зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- ✓ Хашаат сумын ОНХС: 149.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Халуун усны барилга"-ын ажил, Цагаан хад, Цайдам багуудад гаргасан 36.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худгийн цооногийн ажлуудад түрээслэгч иргэдтэй төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн түрээсийн гэрээ байгуулаагүй, орлого төвлөрүүлээгүй.
- ✓ Батцэнгэл сумын ОНХС: 39.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Халуун усны барилга"-ын ашиглагч буюу түрээслэгч иргэнтэй төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн түрээсийн гэрээ байгуулаагүй, орлого төвлөрүүлээгүй.
- ✓ Хангай сумын ОНХС: 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Чандмана багийн барилга засварлах ажлын гүйцэтгэгч нь гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй ашиглалтгүй байна.
- ✓ Өндөр-Улаан сумын ОНХС: Шинээр хэрэгжүүлсэн 45.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ЗДТГ-ын урд талбайг засах ажлын гүйцэтгэгч нь гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй, ашиглалт хангалтгүй.
- ✓ Тариат сумын ОНХС: 51.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эрчим хүчний 2 дэд станц шинээр байгуулах ажил болон 25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цагааннуур багт хогийн цэгийн засварын ажлын гүйцэтгэгч нар нь гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй, ашиглаагүй.
- ✓ Тариат сумын ОНХС: 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 54.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй мал угаалгын автомашиныг нийлүүлэгч "Үлэмж заан" ХХК -аас 2023.06.05-ны өдөр хүлээн авсан хэдий ч 2024 оны 05 дугаар сарын байдлаар уг авто машинд тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон улсын дугаар аваагүй.

Аудитаас Төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэх чиглэлийг баримтлан түрээсийн гэрээ байгуулах, төлбөр төлөх хуваарь, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах албан шаардлагыг сумдын Засаг даргад хүргүүлээ.



БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЖ, ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.

3.1 ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАХ-НИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

3.1.1 Аймаг, сумын ИТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна

"ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 9.4, 3.2.2¹²-д ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон тус журмын хэрэгжилтэд аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх хороо хяналт тавьж ажиллахаар зохицуулсан.

ОНХС-ийн 2023 оны хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьсан эсэхийг баримтаар үзэхэд нэр бүхий 8-н сумын ИТХ-аас сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 2,628.9 сая төгрөгийн 145 төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад бүрэн хяналт тавьж ажилласан бол 5-н сумын ИТХ-аас 1,792.4 сая төгрөгийн 61 төсөл арга хэмжээнд хяналтыг түүвэрлэн хэрэгжүүлсэн байна. Харин нэр бүхий 6-н сумын ИТХ болон аймгийн ИТХ-аас ОНХС-ийн журамд заасан хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Нэгтгэн дүгнэж үзэхэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 12,226.4 сая төгрөгийн 352 ТАХ-ний 41% буюу 145 ТАХ-нд аймаг, сумдын ИТХ-аас хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн, 17% хувь 61 ТАХ-нд дутуу, 42% хувь 146 ТАХ-ний гүйцэтгэлд хяналтыг огт хэрэгжүүлээгүй байна.

Дүрслэл 7. Аймаг, сумын ИТХ-аас хяналт хэрэгжүүлсэн байдал



Эндээс үзэхэд бүх шатны ИТХ-д хяналтыг хэрэгжүүлж ажиллах өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 24 төсөл арга хэмжээнд аймгийн ИТХ-ын хяналтын хороо хяналт тавиагүй. /Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2024.06.04-ний өдрийн 81 тоот албан бичиг/
- ✓ Хангай, Эрдэнэмандал, Батцэнгэл, Өлзийт, Хашаат, Эрдэнэбулган, Цахир сумдын ИТХ аас 122 төсөл арга хэмжээнд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аудитын дүнд үндэслэн "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын дагуу хяналтыг хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах албан шаардлагыг сумын ИТХ-ын дарга нарт хүргүүлээ.

¹² Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих



Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас аймаг, сумын ОНХС-ийн 2023 оны хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 333 ТАХ-ний 11% буюу 37 ТАХ-нд хяналт, шалгалт хийж, 89% буюу 296 ТАХ-нд хяналт тавьж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10¹³, 69 дүгээр зүйлийн 69.1¹⁴ дэх хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Аудитаас Төсвийн тухай хууль, "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу дотоод аудитыг хэрэгжүүлж, үр дүнг үнэлж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Нэгдсэн тайланд уламжлах санал:

Аудитын илрүүлэлтээс харахад аймаг болон 7 сумын ИТХ-аас орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. Журмын дагуу чиг үүргээ хэрэгжүүлээгүйд тооцох хариуцлагатай холбоотой зүйл тусгагдаагүй нь журмын хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэл үүссэн байна. Иймд журамд эрх, үүрэг, хяналтыг хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох заалтыг тодорхой тусгаж өгөх нь зүйтэй байна.

3.1.2. Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс ТАХ гэрээний хугацаанд хийгдэхгүй удааширч, төсвийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдах, ард иргэдийн хүртэх үр өгөөж буурч байна

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.2.2.1-д заасны дагуу төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Дүрслэл 8. ОНХС-ийн хөрөнгөд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдал



Тайлант онд хэрэгжүүлсэн 12,226.4 сая төгрөгийн 352 ТАХ-ээс захиалагчийн хяналт хэрэгжүүлбэл зохих 12,578.8 сая төгрөгийн 333 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 83 хувь буюу 10,474.5 сая төгрөгийн 276 ТАХ-нд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, 17 хувь буюу 2,104.3 сая төгрөгийн 57 ТАХ-ний үр дүнд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Захиалагчийн зүгээс гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллуулахаар томилсон ажлын хэсэг нь ТАХ-нд хяналт хэрэгжүүлэх төлөвлөгөө, хуваарийг боловсруулж, баталсан хуваарийн дагуу гүйцэтгэгч байгууллагыг ажлын гүйцэтгэлтэй тогтмол танилцаж, зураг төсөв, ажлын даалгаварт заасны дагуу хийгдэж буй эсэх, ажил, үйлчилгээнд чанар стандартын шаардлага хангасан бараа материалыг ашиглаж буй

¹³ Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

¹⁴ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна



эсэхэд хяналт тавиагүйгээс ТАХ үр дүнгүй, чанар стандартын шаардлага хангахгүй болох эрсдэлийг үүсгэж байгаа нь аудитын явцад ажиглагдсан.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Аймгийн ОНХС: 993.1 сая төгрөгийн үнийн дүн бүхий авто зам засварын 4 ажилд захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй нь Авто замын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6¹⁵ дахь заалттай нийцэхгүй байна.
- ✓ Сумдын ОНХС: Цэцэрлэг сум 306.3 сая төгрөгийн 17 ТАХ, Жаргалант сум 425.8 сая төгрөгийн 30 ТАХ, Эрдэнэбулган сум 379.2 сая төгрөгийн 6 ТАХ -ний ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй нь Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын 4.2.2.1¹⁶ дэх заалттай нийцэхгүй байна.


Иймд зөрчлийг таслан зогсоох, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг мөрдөж, захиалагчийн болон үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

3.1.3. Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, шийдвэрийн биелэлт 69.8 хувьтай байна

Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас 2022 онд хийсэн ОНХС-ийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудитаар нийт 32,754.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох 39 албан шаардлага, 155.1 сая төгрөгийн 4 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлжээ.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхэд 1,256.4 сая төгрөгийн 29 албан шаардлага бүрэн хэрэгжиж, биелэлт 74.4 хувьтай, харин 155.1 сая төгрөгийн 1 зөвлөмж хэрэгжиж, зөвлөмжийн биелэлт 25 хувьтай байна.

Дүрслэл 9. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт /аймаг, сумдаар/



¹⁵ “Авто зам, замын байгууламжийн их засварын ажлын техник, технологийн хяналтыг тусгай зөвшөөрөл бүхий этгээдүүдээс сонгон шалгаруулж, гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ”

¹⁶ “төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг батлагдсан төсөвт өртөг, гэрээний нийт дүн, холбогдох норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарь, санхүүжилтийн хуваарийн дагуу тулган шалгаж, хянан баталгаажуулах”



Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр ТЭЗҮ, зураг төсөвгүй, иргэдийн саналаар дэмжигдээгүй ТАХ хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталдаг, ХАА-ны журам зөрчсөн, хөрөнгийг бүртгэлд тусгадаггүй зөрчлүүд жил бүр давтагдан гарсаар байна.

Иймд зөрчлийг таслан зогсоох, өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.

3.2. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫГ УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД БҮРЭН МЭДЭЭЛЭЭГҮЙ, 1,035.7 САЯ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРТГЭЛ ТАЙЛАНД ТУСГААГҮЙ БАЙНА

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу хугацаанд нь тайлагнасан байна


“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2¹⁷, 9.9¹⁸-т заасны дагуу 19 сумын ЗДТГ-аас ОНХС-ийн 2023 оны гүйцэтгэл, зарцуулалтын тайланг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т ирүүлж нэгтгүүлсэн байна. Мөн журмын 9.11¹⁹-т заасны дагуу аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн гүйцэтгэлийг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнажээ.

3.2.2. ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжсэн нийт ТАХ-ний 91 хувь буюу 10,583.0 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнасан байна

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2²⁰, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2²¹-д төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгэхээр заасан.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон нийт 11,629.7 сая төгрөгийн 333 ТАХ-нээс 10,583.0 сая төгрөгийн 329 ТАХ-г аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, эзэмшигч байгууллагын даргын тушаал зэргийг үндэслэн нягтлан бодох бүртгэлд тусгаж, 1,035.7 сая төгрөгийн 4 ТАХ буюу нийт хэрэгжсэн ТАХ-ний 9 хувийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Дүрслэл 10. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ



¹⁷ Сум дүүргийн ЗДТГ-ын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана

¹⁸ “Аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж жил бүрийн 03 дугаар сарын 10-ны дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орон нутгийн хөгжлийн сангийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана”

¹⁹ “ОНХС-ийн орлого, зарлага нь тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийг тухайн аймаг, нийслэлийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэнэ”

²⁰ Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага

²¹ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна



Бүртгэлд тусгасан 10,583.0 сая төгрөгийг ангилж харуулбал:

- Үндсэн хөрөнгөөр-6,531.2 сая төгрөг буюу 62 хувь
- Бараа материалаар-137.7 сая төгрөг буюу 1 хувь
- Урсгал зардлаар-3,925.1 сая төгрөг буюу 37 хувь

Аудитын илрүүлэлт:

- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн 269.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн “Мал нядалгааны цэг”, 647.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”, 98.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хотонт сумын Наадмын талбай” нийт 1,015.7 сая төгрөгийн 3 ТАХ-г нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй.
- ✓ Тариат сумын 2023 оны ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Гудамж талбайн тохижилт, замын тэмдэг тэмдэглэгээ" хийх 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-г нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй.

Аудитаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г нягтлан бодох бүртгэлд тусгах, албан шаардлагыг аймаг, сумдын Засаг даргад хүргүүлээ.

3.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт ТАХ-ний 28.8 хувийг удирдлагын мэдээллийн системд мэдээлээгүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2²² дахь заалтын дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал, хяналт, бүртгэлийг аймаг, сумдын ЗДТГ нь удирдлагын мэдээллийн системд оруулах чиг үүрэгтэй.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 5,976.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 10,129.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 415, нийт 16,105.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 447 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталснаас удирдлагын мэдээллийн системд 66.4 хувь буюу 297 ТАХ-г бүрэн мэдээлж, 4.6 хувь буюу 21 ТАХ-г дутуу, 28.8 хувь буюу 129 ТАХ-г огт мэдээлээгүй байна.

Аймаг, сумдын УМС-д мэдээлэл оруулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 11. УМС-д ТАХ-г оруулсан байдал

| № | Сумын нэр | Нийт батлагдсан ТАХ-ний тоо | | Удирдлагын мэдээллийн системд | | | | | |
|---|------------------|-----------------------------|------------|-------------------------------|------------|-----------------|------------|-----------------|------------|
| | | | | Бүрэн оруулсан | | Дутуу хэрэгжсэн | | Огт мэдээлээгүй | |
| | | Тоо | Мөнгөн дүн | Тоо | Мөнгөн дүн | Тоо | Мөнгөн дүн | Тоо | Мөнгөн дүн |
| 1 | Ихтамир сум | 21 | 572.2 | | | | | 21 | 572.2 |
| 2 | Чулуут сум | 29 | 479.9 | 29 | 479.9 | | | | |
| 3 | Хангай сум | 15 | 468.8 | 15 | 468.8 | | | | |
| 4 | Тариат сум | 34 | 666.9 | | | | | 34 | 666.9 |
| 5 | Өндөр-Улаан сум | 34 | 691.5 | 34 | 691.5 | | | | |
| 6 | Эрдэнэмандал сум | 40 | 822.9 | 20 | 408.2 | 15 | 360.2 | 5 | 54.5 |
| 7 | Жаргалант сум | 37 | 928.1 | | | | | 37 | 928.1 |

²² ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ



| | | | | | | | | | |
|------------|-----------------------|------------|-----------------|------------|----------------|-----------|----------------|------------|----------------|
| 8 | Цэцэрлэг сум | 20 | 378.8 | 20 | 378.8 | | | | |
| 9 | Хайрхан сум | 18 | 531.6 | 18 | 531.6 | | | | |
| 10 | Батцэнгэл сум | 20 | 494 | 20 | 494 | | | | |
| 11 | Өлзийт сум | 20 | 433.3 | 20 | 433.3 | | | | |
| 12 | Өгийнуур сум | 10 | 364 | 10 | 364 | | | | |
| 13 | Хашаат сум | 15 | 393.7 | 15 | 393.7 | | | | |
| 14 | Хотонт сум | 20 | 658.5 | | | | | 20 | 658.5 |
| 15 | Цэнхэр сум | 14 | 479.3 | 14 | 479.3 | | | | |
| 16 | Төвшрүүлэх сум | 17 | 271.2 | 17 | 271.2 | | | | |
| 17 | Булган сум | 12 | 338.9 | 12 | 338.9 | | | | |
| 18 | Эрдэнэбулган сум | 13 | 744.4 | 12 | 579.8 | | | 1 | 164.6 |
| 19 | Цахир сум | 26 | 411.4 | 26 | 411.4 | | | | |
| 20 | Архангай аймгийн ОНХС | 32 | 5,976.1 | 15 | 2,483.1 | 6 | 1,469.3 | 11 | 2023.7 |
| Дүн | | 447 | 16,105.5 | 297 | 9,207.5 | 21 | 1,829.5 | 129 | 5,068.5 |

Аудитын илрүүлэлт:

- ✓ Аймгийн ОНХС: 3,493.1 сая төгрөгийн 17 ТАХ-г
- ✓ Сумдын ОНХС: Ихтамир сум 572.2 сая төгрөгийн 21, Тариат сум 666.9 сая төгрөгийн 34, Жаргалант сум 928.1 сая төгрөгийн 37, Хотонт сум 658.5 сая төгрөгийн 20, Эрдэнэбулган сум 146.4 сая төгрөгийн 1, Эрдэнэмандал сум 414.7 сая төгрөгийн 20, нийт 150 ТАХ-г УМС-д мэдээлээгүй байна.

Аудитаас "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг мөрдөж сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ-ний мэдээллийг удирдлагын мэдээллийн системд хугацаанд нь бүрэн мэдээлэх албан шаардлагыг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

3.2.4. Аймгийн ОНХС-ийн 2023 оны хөрөнгийн зарцуулалтын 89.5 хувь нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн мэдээлсэн байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн 2023 оны хөрөнгөөр бүрэн хэрэгжсэн нийт 12,226.4 сая төгрөгийн 333 ТАХ-ний 10.5% буюу 35 ТАХ-ний мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Ихтамир сум 11 ТАХ -ний мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд огт мэдээлээгүй.
- ✓ Өндөр-Улаан сум: 5 төсөл арга хэмжээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд огт мэдээлээгүй, 19 төсөл арга хэмжээг хугацаа хоцроон мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.1, 6.3.9 дэх заалттай нийцэхгүй байна.

Аудитаас шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг хугацаанд нь мэдээлэх албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн хөгжлийн санд 831.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй байна
- ✓ Иргэдийн санал аваагүй нийт 6,647.8 сая төгрөгийн 67 төсөл арга хэмжээг аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна
- ✓ Төсвийн тухай хуульд заасан шаардлага шалгуур хангаагүй 6,924.6 сая төгрөгийн 75 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна
- ✓ Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн нийт ТАХ-ний 10.2 хувь нь төлөвлөсөн зорилтод үр дүнд хүрээгүй байна
- ✓ Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс бодит гүйцэтгэлд үндэслээгүй 175.2 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгосон, 1,336.8 сая төгрөгийн 19 ТАХ-ийг төлөвлөсөн хугацаанаас хэтэрсэн, 370.8 сая төгрөгийн ТАХ чанарын шаардлага хангахгүй ашиглалтын явцад эвдэрч ашиглагдахгүй болсон нь төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулж иргэдийн хүртэх үр өгөөжийг бууруулсан байна
- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 420.3 сая төгрөгийн 10 ТАХ-г гэрээ байгуулж ашиглуулаагүйгээс хөрөнгө эзгүйдэж үрэгдэж, шамшигдах эрсдэл бий болсон байна.
- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 1,035.7 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэл тайланд тусгаагүй байна
- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт ТАХ-ний 28.8% буюу 5068.5 сая төгрөгийн 129 ТАХ-ний мэдээллийг удирдлагын мэдээллийн системээр иргэд олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.
- ✓ Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС САНГИЙН ХӨРӨНГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ БУУРЧ БАЙНА.

Аудитын дүн: Аудитаар нийт **5,079.1 сая төгрөгийн** зөрчил илэрснээс 5,079.1 сая төгрөгийн зөрчилд 45 албан шаардлага, 3 заалт бүхий зөвлөмжийг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга болон холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

-----o0o-----



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна .

Аймгийн ИТХ-ын дарга Б.Батжаргалд

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-аар хэлэлцэхдээ иргэд, олон нийтийн саналаар дэмжигдээгүй, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй хөрөнгө оруулалтын ажлыг батлахгүй байх

Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмидад

1. ОНХС-ийн үйл ажиллагааг Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлд заасны дагуу төлөвлөх, иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх
2. ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэх, төсөвт байгууллагын урсгал болон хөрөнгийн зардлыг санхүүжүүлэх бус орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зориулалтын дагуу зарцуулахаар төлөвлөх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсний дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 07 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2024 оны 11 дүгээр сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



АРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 1122

Эрдэнэбулган сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.
